



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2019 оны 3 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 3 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17%-иар буюу 445 сая ам.доллараар өсч 3,057 сая ам.доллар байв. Үүнд экспорт 20%-иар буюу 289 сая ам.доллараар, импорт 14%-иар буюу 155 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 134 сая ам.доллараар өсч 486 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 3 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	2,076	2,613	3,057	537	26%	445	17%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	1,300	1,482	1,772	183	14%	289	20%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	776	1,130	1,286	354	46%	155	14%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		(728)	-39%	524	352	486	(172)	-33%	134	38%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2019 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 125 сая ам.доллараар өсч 529 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 62% буюу 1,888 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 378 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 0.2%-иар буурсан бол БНХАУ-тай хийсэн худалдаа 15%-иар өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2019 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 27%-иар, өмнөх сараас 32%-иар өсч 2.212-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирахад хөрөнгө оруулалтын барааны импортын үнийн бууралт болон зэсийн баяжмалын экспортын үнийн өсөлт голлон нөлөөлөв.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2019 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 20%-иар буюу 289 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 19 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.4 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		1,202	92%	1,374	93%	1,663	94%	172	14%	13%	289	21%	19%		
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	366	380	29%	338	463	31%	361	504	28%	82	22%	6%	41	9%	3%
1.2. Чулуун нүүрс	8,016	538	41%	6,613	509	34%	7,733	642	36%	(29)	-5%	-2%	132	26%	9%
1.3. Боловсруулаагүй нефть	1,839	93	7%	1,631	101	7%	1,621	88	5%	8	8%	7%	(13)	-13%	-7%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	1,106	70	5%	1,441	64	4%	2,072	107	6%	(6)	-9%	0%	43	67%	3%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	1,111	44	3%	2,950	124	8%	4,665	196	11%	81	184%	6%	72	58%	5%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	27	40	3%	33	60	4%	44	63	4%	20	49%	2%	2	4%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	53	12	1%	78	25	2%	111	41	2%	13	106%	7%	16	62%	7%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	9	1%	1	10	1%	1	12	1%	1	17%	0%	2	18%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	1	0%	0	1	0%	(0)	-4%	0%	(0)	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	-	0%	0	0	0%	0	-	0%	(0)	0%	0%	(0)	0%	0%
1.11. Бусад	134	15	1%	164	16	1%	75	12	1%	2	10%	0%	(5)	-30%	0%
2. Мал аж, ахуй	121	36	3%	123	42	3%	111	43	2%	6	16%	0%	1	3%	0%
2.1. Амьд мал, малын мах	3	5	0%	6	14	1%	7	14	1%	9	170%	7%	(0)	-2%	0%
2.2. Арьс, шир	116	10	1%	112	6	0%	98	4	0%	(4)	-40%	0%	(2)	-30%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	1	0%	0	2	0%	0	2	0%	0	27%	0%	1	0%	0%
2.4. Ноолуур	1	16	1%	2	17	1%	2	15	1%	1	5%	0%	(1)	-8%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	2	3	0%	2	3	0%	3	7	0%	(0)	-1%	0%	4	130%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	1	0	0%	(0)	-12%	0%	0	4%	0%
3. Газар тариалан	17	2	0%	2	1	0%	13	3	0%	(1)	-47%	0%	2	263%	0%
4. Аж үйлдвэрлэл	117	60	5%	51	66	4%	118	62	5%	6	10%	0%	(3)	-5%	0%
4.1. Хүнс	5	19	1%	6	20	1%	7	18	1%	1	7%	0%	(2)	-10%	0%
4.2. Ноолууран адал	0	3	0%	0	4	0%	0	8	0%	1	28%	0%	4	79%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, адал	0	3	0%	1	3	0%	1	2	0%	1	23%	0%	(1)	-23%	0%
4.4. Уул уурхай	7	25	2%	8	27	2%	36	27	2%	2	10%	0%	(0)	-1%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	255%	0%	0	19%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	0	8	1%	1	9	1%	0	5	0%	0	4%	0%	(4)	-43%	0%
4.7. Бусад	104	1	0%	35	1	0%	74	1	0%	0	13%	0%	(0)	-4%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	33%	0%	(0)	-30%	0%
Нийт дүн		1,300		1,482		1,772		183	14%		289	20%			

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)


Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2019 оны эхний 3 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
1. Уул уурхай	244		45		289	21%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	33	80%	8	20%	41	9%
1.2. Чулуун нүүрс	93	70%	39	30%	132	26%
1.3. Боловсруулаагүй нефть	(1)	4%	(13)	96%	(13)	-13%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	32		10		43	67%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	72	101%	(0)	-1%	72	58%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	16	642%	(13)	-542%	2	4%
1.7. Жонош, лейцит, нефелинт	12	76%	4	24%	16	62%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(0)	-5%	2	105%	2	18%
1.11. Бусад	(14)	284%	9	-184%	(5)	-30%
2. Мал аж, ахуй	(2)		3		1	3%
2.1. Амьд мал, малын мах	1	-524%	(1)	624%	(0)	-2%
2.2. Арьс, шир	(1)	35%	(1)	65%	(2)	-30%
2.3. Малын өлөн гэдэс	(1)	-88%	1	188%	1	0%
2.4. Ноолуур	(6)	445%	5	-345%	(1)	-8%
3. Газар тариалан	3		(0)		2	263%
4. Аж үйлдвэрлэл	14		(17)		(3)	-5%
5. Бусад	(0)		(0)		(0)	-30%
Нийт дүн	258		31		289	20%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2019 оны эхний 3 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 258 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 31 сая ам.доллараар тус тус өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 126 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 48 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 14 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 17 сая ам.доллараар буурсан байна.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 3 дугаар сард 1,301 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1.9%-иар, өмнөх сараас 1.4%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,439; 86 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 5.3%-иар буурсан бол төмрийн хүдэр 22.9%-иар өссөн, өнгөрсөн сараас зэс 2.2%-иар өссөн хэдий ч төмрийн хүдэр 2.0%-иар буурсан. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 3 дугаар сард 83 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 8.2%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 2.5%-иар буурлаа.

Импорт 2019 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 14%-иар буюу 155 сая ам.доллараар өсөв. Импортын 14 нэгж хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 11 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%?	Дүн	Өсөлт	%?
Хэрэглээний бүтээгдэхүүн		255	33%		322	28%		351	27%	67	26%	9%	29	9%	3%
Түргэн эдэлгээтэй	197	143	18%	205	175	15%	179	170	13%	31	22%	4%	(5)	-3%	0%
Хүнс	72	96	12%	97	123	11%	84	120	9%	27	28%	3%	(3)	-2%	0%
Эм, тариа	1	22	3%	0	22	2%	1	20	2%	1	3%	0%	(2)	-9%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	124	26	3%	107	30	3%	94	30	2%	4	16%	1%	0	1%	0%
Удаан эдэлгээтэй	53	111	14%	30	147	13%	67	181	14%	36	32%	5%	34	23%	3%
Гутал, хувцас, цүнх	15	12	2%	11	15	1%	16	14	1%	3	27%	0%	(2)	-11%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	24	21	3%	9	24	2%	37	23	2%	3	14%	0%	(0)	-2%	0%
Авто машин, түүний салбэр хэрэгсэл	0	66	9%	0	91	8%	0	126	10%	25	38%	3%	35	39%	3%
Бусад удаан эдэлгээтэй бараа	14	12	2%	10	17	2%	13	18	1%	5	39%	1%	1	7%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	219	265	34%	377	400	35%	300	519	40%	135	51%	17%	119	30%	11%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	6	193	25%	4	256	23%	6	375	29%	63	33%	8%	119	46%	10%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	34	4%	0	75	7%	1	125	10%	41	123%	5%	50	67%	4%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	6	159	20%	4	181	16%	5	249	19%	22	14%	3%	68	38%	6%
Барилгын материал	58	45	6%	93	93	8%	138	104	8%	48	105%	6%	11	12%	1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	7	27	3%	7	51	5%	5	41	3%	24	90%	3%	(11)	-21%	-1%
Аж үйлдвэрлэлийн орц	268	96	12%	345	176	16%	439	147	11%	80	83%	10%	(29)	-16%	-3%
Хүнсний орц	9	3	0%	126	39	3%	8	4	0%	36	1042%	5%	(35)	-89%	-3%
Химийн бүтээгдэхүүн	32	19	2%	43	24	2%	48	24	2%	6	31%	1%	0	1%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	7	5	1%	13	5	0%	19	7	1%	1	15%	0%	2	30%	0%
Цахилгаан эрчим хүч	0	24	3%	0	36	3%	0	37	3%	12	51%	2%	1	3%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	42%	0%	(0)	-29%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	171	45	6%	193	71	6%	226	74	6%	25	55%	3%	3	5%	0%
Нефтийн бүтээгдэхүүн	268	159	20%	345	231	20%	439	267	21%	72	45%	9%	36	16%	3%
Дизель түлш	145	80	10%	207	134	12%	263	163	13%	54	68%	7%	29	22%	3%
АИ-92, АИ-95	86	53	7%	79	55	5%	126	69	5%	2	4%	0%	14	26%	1%
А-80 болон бусад	37	27	3%	59	42	4%	50	35	3%	16	59%	2%	(7)	-18%	-1%
Бусад	4	2	0%	6	2	0%	34	2	0%	0	14%	0%	(1)	-29%	0%
Нийт дүн		776		1,130			1,286			354	46%		155	14%	

%? - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2019 он эхний 3 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	30	102%	(1)	-2%	29	9%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	162	136%	(43)	-36%	119	30%
Аж үйлдвэрлэлийн орц	(50)		22		(29)	-16%
Нефтийн бүтээгдэхүүн	54	151%	(18)	-51%	36	16%
Дизель түлш	35	120%	(6)	-20%	29	22%
АИ-92, АИ-95	26	180%	(11)	-80%	14	26%
А-80 болон бусад	(6)	86%	(1)	14%	(7)	-18%
Бусад	1		(2)		(1)	-29%
Нийт дүн	198	127%	(43)	-27%	155	14%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9 хувиар буурсан бол өмнөх сараас 2 хувиар өсч тонн тутамд 616 ам.долларт хүрэв.